

**ДУНДГОВЬ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
2020 ОНЫ ЭЭЛЖИТ СОНГУУЛЬД БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ  
Т.БЯМБАЦЭРЭНГИЙН МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

1. Төрийн албыг цомхон, чадварлаг, мэргэшсэн тогтвортой ажиллах, төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулна.
2. Дундговь аймгийн эрүүл мэндийн салбарт оношилгоо эмчилгээний шинэ технологийг нэвтрүүлж компьютер томографын аппараттай болгож иргэдийг орон нутагтаа оношлуулах нөхцөл боломжоор хангана.
3. Эмч эмнэлгийн мэргэжилтний нийгмийн асуудлыг шийдвэрлэх, орон нутагт тогтвор суурьшилтай ажиллах боломжийг бүрдүүлнэ.
4. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүрэх эрүүл мэндийн үйлчилгээг бодлогоор дэмжин, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд эрүүл мэндийн ээлтэй орчинг бүрдүүлнэ.
5. Эрүүл мэндийн чиглэлээр хийгдэх төсөл хөтөлбөрүүдийг дэмжиж ажиллана.
6. Жоншны бичил уурхайн ашиглалтыг Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны шаардлагыг хангаж, хэвийн явуулах хөдөлмөр хуваарилалт, зохион байгуулалтын зохистой хэлбэрийг иргэдийн оролцоотойгоор шийдвэрлэнэ.
7. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэж буй ажлын гүйцэтгэлийн хяналтын тогтолцоог сайжруулах, иргэдийн хяналтын тогтолцоог бий болгоно.
8. Жижиг дунд үйлдвэрийг дэмжих сан, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналт, шинжилгээ үнэлгээний ажлыг иргэд, орон нутгийн төрийн бус байгууллага хамтран гүйцэтгэдэг механизм бий болгох асуудлыг шийдвэрлүүлнэ.

**Мөрийн хөтөлбөр боловсруулсан:**



**Т.Бямбацэрэн**

